

Статистикийн хэлтэс

Н..... танаа



Төв аймгийн 2008 оны хүн амын ажил эрхлэлтийн байдал

Зуунмод

2009 он

ГАРЧИГ

I. Товч тайлбар, тодорхойлолт.

II. Хүн амын ажил эрхлэлтийн танилцуулга.

III. Судалгаа.

III.1. Хүн амын ажил эрхлэлтийн динамик эгнээний хэлхээ үндсэн үзүүлэлтүүдийн тооцоолол.

III.2. Ажиллагсадын тооны динамик эгнээний суурь үндсэн үзүүлэлтүүдийн тооцоолол.

III.3. Ажил эрхлэлтийн 1994 оныг 2008 онтой харьцуулсан үзүүлэлтийн тооцоолол.

III.4. Динамик хандлагын шинжилгээ.

III.5. Цикл хэлбэлзэлийн шинжилгээ.

IV. ДҮГНЭЛТ, САНАЛ

ӨМНӨХ ҮГ

Статистикийн тухай “ Монгол Улсын хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх заалтыг үндэслэн хүн амын ажил эрхлэлтийн судалгаа ХН-1, Ажилгүйчүүдийн мэдээ АХ-3 тайлан, мэдээг аймгийн хэмжээнд зохион байгуулж, дүнг Үндэсний Статистикийн Хороонд хүргүүлэх, холбогдох мэдээ, судалгааг хийж удирдлага болон хэрэглэгч байгууллагууд, иргэдэд үйлчиллээ.

2008 оны дүнд үндэслэсэн энэхүү танилцуулгад суурин хүн амын болон хөдөлмөрийн насны хүний насны бүтэц, хувийн жин, хүн амын болон хөдөлмөрийн насны хүн амын ажил эрхлэлтийг байгууллагын төрөл, эдийн засгийн үйл ажиллагааны салбар, ажил мэргэжлийн ангилал, эдийн засгийн салбараар, өмчийн хэлбэр, эдийн засгийн салбарын ангилалаар 5-9 жилийн гүйцэтгэлээр зэрэгцүүлэлт хийж харуулав.

Танилцуулга нь 4 бүлэг, 50 хавсралт хүснэгт графикаас бүрдэж байгаа бөгөөд дүнг бүсчилсэн байдлаар Төв, Хойд, Баруун, Зүүн бүс гэсэн ангиллаар зэрэгцүүлэлт хийн гаргалаа.

Аймгийн хүн амын ажил эрхлэлтийн өнөөгийн байдалд дүгнэлт хийж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг боловсруулах, төлөвлөхөд энэхүү танилцуулга судалгаа суурь материал болно гэдэгт итгэж байна.

СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

I. ТОВЧ ТАЙЛБАР, ТОДОРХОЙЛОЛТ

Монгол Улсын хэмжээнд хөдөлмөр эрхлэлт,ажиллах хүчний мэдээ,тайлан гаргах,судалгаа явуулах,хөдөлмөр эрхлэлт, ажиллах хүчний холбогдолтой үндсэн үзүүлэлтүүдийг тооцоход энэхүү нэгдсэн ойлголт,тодорхойлолтыг ашиглана.

1. Хувь хүний бүрэн хөдөлмөр эрхлэлт: иргэн хүн оюуны болон биеийн хүчээ бүрэн ашиглан ажиллаж болох боломжит түвшинг хэлнэ. Энэ нь хувь хүний оюуны болон биеийн хүчээ бүрэн ашиглан бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгоход зориулж буй ердийн ажлын өдрийн үргэлжлэх хугцаагаар тодорхойлогдоно.

2. Хувь хүний бүрэн бус хөдөлмөр эрхлэлт: хэдийгээр цалин хөлс,орлоготой ажил эрхэлж байгаа боловч ямар нэг шалтгаанаар ердийн ажлын өдөр нь тогтоосон хугацаанаас бага буюу хагас цагаар ажилладаг, нэмэгдэл цагаар ажиллан орлогоо нэмэгдүүлэхийг хүсч байгаа шалгуураар тодорхойлогдоно. Бүрэн бус хөдөлмөр эрхлэлтийг тухайн иргэн үндсэн ажил дээрээ нэмж давхар ажил эрхэлхийг хүсч буй нэмэгдэл цагаар тооцож гаргана. Бүрэн бус хөдөлмөр эрхлэлт (шинж тэмдэг) нь нэмэлт орлого олох хүсэл, ажиллах хүч болон мэргэжил, ур чадварын бүрэн бус ашиглалт, бүтээмжийн бага түвшин зэргээр тодорхойлогдоно.

Хагас цагаар ажиллагч-Хөдөлмөрийн тухай хуулиар тогтоосон ердийн ажлын өдрийн үргэлжлэх хугцаанаас бага цагаар ажиллаж байгаа ажиллагчийг хэлнэ.аа

Давхар ажил эрхлэлт-Үндсэн ажлынхаа хажуугаар зохих зөвшилцөл, гэрээний дагуу болон төрөл бүрийн хэлбэрээр бие даасан нэгээс илүү байгууллагын бизнесийн үйл ажиллагаанд оюуны болон биеийн хүчээ зарцуулан мөнгөн болон мөнгөн бус хэлбэрээр цалин,хөлс авч ажиллахыг хэлнэ.

3. Хөдөлмөрийн насны хүн ам-16-гаас 59 насны нийт хүн ам болно.

(Хөдөлмөрийн тухай хуулийн дагуу)

4. Хөдөлмөрийн насны хөдөлмөрлөх чадвартай хүн ам- хөдөлмөрийн насны хөдөлмөрийн бүрэн чадвартай болон албан ёсны нотолгоогоор хөдөлмөрлөх чадвараа 30 хүртэл хувиар алдсан нь тогтоогдсон хөдөлмөрлөх боломжтой хүн амыг хэлнэ.

5. Хувь хүний хөдөлмөр эрхлэлт- эдийн засгийн үйл ажиллагаа буюу үйлдвэрлэлд оролцож байгаа хэлбэрээрээ албан ба албан бус секторт байж болно.

Эдийн засгийн үйл ажиллагаа-Зах зээлд болон хувь хүний хэрэглээнд зориулан үйлдвэрлэж буй нийт бүтээгдэхүүн, үйлчилгээг хэлнэ. НҮБ-ын үндэсний тооцооны системийн хүрээнд тодорхойлохдоо бүтээгдэхүүн, үйлчилгээнд: худалдах, солилцох, өөрийн аж ахуйд хэрэглэх зорилгоор боловсруулсан түүхий эд материал, зах зээлд нийлүүлж байгаа бүхий л бүтээгдэхүүн, үйлчилгээг, зах зээлд худалдах, өөрийн аж ахуйд хэрэглэх зорилгоор өрхийн үйлдвэрлэж байгаа бүтээгдэхүүн, үйлчилгээг хамруулна.

Үйлдвэрлэл-хөдөлмөр, капитал, бараа, үйлчилгээг ашиглаж эдийн засгийн үйл ажиллагаа явуулахыг хэлнэ.

Албан сектор -албан ёсны статистикт бүрэн хамрагдан, хуулийн этгээдийн хяналтын дор эсвэл хуулийн этгээд болж эдийн засгийн үйл ажиллагаа явуулж байгаа хүрээг хэлнэ.

Албан бус сектор-албан ёсны статистик , татварт бүрэн хамрагдаагүй , аж ахуйн нэгжийн улсын бүртгэлд ороогүй, орлогыг нь тодорхойлох боломжгүй, орлого олох зорилгоор эдийн засгийн үйл ажиллагаа явуулж буй хүрээг хэлнэ.

6. Хүн амын хөдөлмөр эрхлэлтийн байдал – хөдөлмөр эрхэлж буй хүн амыг тухайн хүний ажиллаж буй байгууллага бусад хүмүүстэй харьцах эрх мэдлийн хэмжээ, ажил үүргийн болон хариуцлагын шинж байдал,статусаар нь дараах байдлаар ангилна. Үүнд:

- Гэрээгээр ажиллагч -төрийн болон төрийн бус байгууллагын албан хаагч, хөдөлмөрийн болон ажил гүйцэтгэх гэрээ байгуулан хөлслөгдөн ажиллагч байна. Мөн хөлсний болон хувиараа хөдөлмөр эрхлэдэг өндөр насны тэтгэвэр авагчид, цалин хөлс авч үйлдвэрлэлийн дадлага хийж буй оюутнууд энэ ангилалд хамаарна.
- **Ажил олгогч** - эдийн засгийн үйл ажиллагаатай холбоотой шийдвэрийг бие даан гаргаж, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээнээс олсон ашиг буюу ашиг олох боломжоос шууд хамаарах бизнесийг хувиараа эрхлэдэг болон урт хугцаагаар нэг буюу түүнээс дээш хүнийг хөдөлмөрийн болон ажил гүйцэтгүүлэх гэрээний үндсэн дээр ажилд авч хөдөлмөр эрхлүүлж буй эзэн, байгууллагын удирдлагыг хэлнэ.
- **Хувиараа ажиллагч** - хувийн хэвшлийн үйлдвэр, аж ахуйн газартаа хувиараа буюу нэг ба түүнээс дээш тооны түнштэй хамтран хөдөлмөр эрхэлж буй болон өөртөө урт хугацаагаар ажиллагч авч ажиллуулдаггүй (харин богино хугцаагаар түр авч ажиллуулж болно) өөрийн бизнесийн үйл ажиллагаа, хөгжил дэвшилд нөлөөлөх шийдвэр гаргадаг хүнийг хэлнэ.

- **Хоршооны гишүүн**-үйлдвэрлэл, үйлчилгээний хоршоонд өөрийн эд хөрөнгө, хөдөлмөрөө сайн дураар нэгтгэж гишүүнээр элссэн, үйлдвэрлэл, борлуулалт, байгууллагын бусад ажлын зохион байгуулалт, хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа болон гишүүдийн дунд ашиг хувиарлах асуудлыг шийдвэрлэхэд бусад гишүүдтэй адил тэгш оролцдог хүнийг хэлнэ.
- **Өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээнд цалин, хөлс авалгүй оролцогч**-тухайн өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээ, аж ахуй эрхлэх үйл ажиллагаанд цалин, хөлс авалгүй оролцож хувийн хэрэглээгээ хангаж буй тухайн өрхөд хамт амьдарч байгаа гишүүд болон тухайн өрхөд хамт амьдардаггүй боловч (хамаатны хүнийхээ) аж ахуй эрхлэх үйл ажиллагаанд дээрхийн адил ажиллаж байгаа иргэнийг хэлнэ.
- **Эдгээр ангилалд хамрагдах боломжгүй ажиллагчид**-тэдний талаар зохих мэдээлэл хангалтгүй эсвэл дээр дурдсан ангиллуудын аль нэгэнд хамруулах бөөлөмжгүй ажиллагчдыг хэлнэ.

7. Эдийн засгийн идэвхтэй хүн ам-бүтээгдэхүүн, үйлдвэрлэл, үйлчилгээ бий болгоход ажиллах хүчээ нийлүүлж байгаа ажиллагчид, нийлүүлэхэд бэлэн байгаа ажилгүйчүүдийг эдийн засгийн идэвхтэй хүн амд тооцоно. Эдийн засгийн идэвхтэй хүн амыг урт хугацаагаар хэмжигдэх байнгын идэвхтэй хүн ам, нэг долоо хоног буюу нэг өдрийн хугацаагаар хэмжигдэх тухайн үеийн идэвхтэй хүн ам буюу “ ажиллах хүч ” гэсэн хоёр аргаар тодорхойлно.

Байнгын идэвхтэй хүн ам – ажилтай болон ажилгүй байсан нь урт хугацаагаар буюу хуанлийн жилийн туршид эрхэлсэн үндсэн үйл ажиллагааных нь байдлаар тодорхойлогддог хүн амыг хэлнэ.

Тухайн үеийн хүн ам буюу ажиллах хүч - ажилтай болон ажилгүй байсан нь нэг долоо хоног буюу нэг өдрийн хугацаанд эрхэлсэн үндсэн үйл ажиллагааных нь байдлаар тодорхойлогдох хүн амыг хэлнэ.

8.Хөдөлмөр эрхэлж буй хүн ам буюу ажиллагчид – тодорхой хугацааны туршид хөлсний болон хувиараа хөдөлмөр эрхэлж байгаа нийт хүн ам болно.

Хөдөлмөр эрхэлж буй хүн ам буюу ажиллагчдын тоог хувь хүний хөдөлмөр эрхлэлтийн үндсэн дээр тооцох ба тухайн хүн давхар ажил эрхэлж буй тохиолдолд үндсэн ажил буюу эрхэлж буй үндсэн үйл ажиллагаанд нь хамруулна. Үүнд:

Хөлсний хөдөлмөр эрхлэгч - хөдөлмөрийн болон ажил гүйцэтгэх гэрээ байгуулан ажиллаж, ажил олгогчдод ажил үйлчилгээ үзүүлснийхээ төлөө мөнгөн болон мөнгөн бус хэлбэрээр цалин, хөлс авдаг иргэнийг хэлнэ. Хөлсний хөдөлмөр эрхлэгчдэд байнгын ажиллагчид, түр ажиллагчид, ажилтай боловч ажлын байрандаа түр эзгүй байгаа байнгын ажиллагчдыг хамруулна.

Байнгын ажиллагчид – хөдөлмөрийн харилцаа нь Монгол Улсын Хөдөлмөрийн болон Төрийн албаны тухай хууль тогтоомжоор зохицуулагдах ба ажил олгогч нь ажилтны зохих татвар, нийгмийн даатгалын шимтгэлийг нь хуулиар тогтоосон хувь хэм-жээгээр төлөх үүрэг хүлээнэ.

Түр ажиллагчид - хөдөлмөрийн харилцаа нь хөдөлмөрийн болон иргэний хуулиар зохицуулагддаг тодорхой ажил үйлчилгээг хөдөлмөрийн ба ажил гүйцэтгэх гэрээ байгуулан ажиллаж зохих татвар, нийгмийн даатгалын шимтгэл төлөх үүргийг өөрөө бие даан хариуцна.

Ажилтай боловч ажлын байрандаа түр эзгүй байгаа байнгын ажиллагчид - өвдсөн, хөдөлмөрийн чадвараа түр алдсан, ээлжийн амралтаа авсан, ажил хаясан, байгаль, цаг уурын нөхцөл, машин механизм эвдэрсэн, цахилгаан, түүхий эд, материал, түлш тасарсан зэрэг шалтгаанаар үйлдвэрлэлийн сул зогсолт гарч, байгууллагын эдийн засгийн үйл ажиллагаа түр хугацаагаар тасалдсан, суралцах, хүүхэд асрах, чөлөөтэй зэрэг тодорхой шалтгаанаар ажилгүй байгаа боловч эргэж ажиллах албан ёсны гэрээтэй ажиллагчид болно.

Хувиараа хөдөлмөр эрхлэгчид - өөрөө бие даан үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэн бий болгосон бүтээгдэхүүн, үйлчилгээ, ашиг орлогоороо хувийн болон өрхийн хэрэглээгээ хагаж байгаа иргэн, өрхийн гишүүд хамрагдана.

9. Ажилгүй иргэн – хөдөлмөрийн насны, хөдөлмөрлөх чадвартай, хөдөлмөр эрхлэх боломжтой, хөдөлмөр эрхлэлтийн албанд бүртгүүлж ажил идэвхтэй хайж байгаа иргэнийг хэлнэ. Тайлант хугацааны ажилгүйчүүдийн тоог хөдөлмөр эрхлэлтийн албадын бүртгэлд үндэслэн тодорхойлно.

- **Хөдөлмөр эрхлэх боломжтой** – бүртгүүлсэн хугацаандаа хөдөлмөр эрхлэлтийн албанаас тухайн иргэний мэргэжил, боловсрол, ажлын ур чадвар болон урьд ажиллаж байсан ажлын нөхцлийг харгалзан санал болгосон ажлын байранд 14 хоногийн дотор ажиллахад бэлэн байгааг;
- **Хөдөлмөр эрхлэлтийн албанд ирж бүртгүүлэх** – ажилгүйчүүдийн бүртгэлийн карт нээлгэж, өөрийн мэргэжил, боловсрол, сонирхол, хаяг, хайж байгаа ажлын талаар мэдээлэл өгөхийг;
- **Ажил идэвхитэй хайх** – хөдөлмөр эрхлэлтийн албанд бүртгүүлж ажил хайж байгаа тухайгаа сард нэгээс доошгүй удаа мэдэгдэж байгаа мөн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд (мэргэжлийн сургалт, нийтийг хамарсан ажил гэх мэт) хамрагдаад 3 сар болоогүй байх (хэрэв 3 сараас дээш хугацаагаар хөдөлмөр эрхлэлтийн албанд ирж ажил хайж байгаа тухайгаа мэдэгдэж, асууж лавлаагүй бол ажил идэвхитэй хайж байгаад тооцохгүй) –ыг хэлнэ.

10. Ажил хайгч иргэн – хөдөлмөр эрхэлдэг боловч ажлаа өөрчлөх хүсэлтэй,эсхүл нэмэлт цагаар буюу ажил гүйцэтгэх гэрээгээр ажил хийх боломжтой, хөдөлмөр эрхлэлтийн албанд бүртгүүлсэн иргэнийг хэлнэ.

11. Ажилгүйдэлд өртөж болзошгүй иргэн – хөдөлмөрийн гэрээ цуцлах мэдэгдэл авсан, байнгын бус орлоготой, хөдөлмөр эрхлэлтийн албанд бүртгүүлсэн иргэнийг хэлнэ.

12. Эдийн засгийн идэвхигүй хүн ам: Байнгын болон тухайн үеийн эдийн засгийн идэвхитэй хүн амд хамаарагдахгүй нийт хүн ам.Үүнд: өндөр насны тэтгэвэр болон хөдөлмөрийн нөхцөл, онцлогоос шалтгаалан тэтгэвэр, тэтгэмж тогтоолгосон, хөдөлмөрийн чадвараа 6 сараас дээш хугацаагаар түр болон бүрэн алдсан, тахир дутуу иргэд болон хөдөлмөрийн насны суралцаж байгаа мөн хөдөлмөрийн насанд хүрээ-гүй хүн амыг хамруулна. Эдийн засгийн идэвхигүй хүн амыг урт хугацаагаар хэмжигдэх байнгын идэвхигүй хүн ам, нэг долоо хоног буюу нэг өдрийн хугацаагаар хэмжиг- дэх тухайн үеийн идэвхигүй хүн ам гэсэн хоёр аргаар тодорхойлно.

13. Хөдөлмөрийн насны , хөдөлмөрийн чадваргүй хүн ам – хөдөлмөрийн насны, албан ёсны эрх бүхий байгууллагын нотолгоогоор хөдөлмөрийн чадвараа 6 сараас дээш хугацаагаар түр болон бүрэн алдсан нь тогтоогдсон, тахир дутуу болон холбогдох хуулийн дагуу тэтгэврийн наснаасаа өмнө тэтгэвэр тогтоолгосон (тэтгэвэр тогтоолгоод ажиллаж байгаа хүн орохгүй) хүн амыг хэлнэ.

14. Хөдөлмөрийн насны суралцагч - Хөдөлмөрийн насны, хөдөлмөрийн чадвартай их, дээд сургууль,коллеж,тусгай мэргэжлийн анхан болон дунд шатны сургууль,мэргэжлийн сургалт,үйлдвэрлэлийн төв,6 сараас дээш хугацаагаар мэргэжлийн сургалтад хамрагдагчид,ЕБС-д суралцаж буй иргэнийг хэлнэ.

15.Хөдөлмөр эрхлээгүй хүн ам- Хөдөлмөрийн насны, хөдөлмөрийн чадвартай, хөлсний болон хувиараа хөдөлмөр эрхэлж цалин хөлс,орлого олдоггүй, хүндэтгэх ба бусад (хөдөлмөр эрхлэх хүсэл сонирхолгүй, хөдөлмөр эрхлэлтийн албанд бүртгэлгүй боловч ажил хайж байгаа,тодорхой шалтгаангүй гэх мэт) шалтгаанаар ажил идэвхитэй эрж хайхгүй байгаа хүн амыг хэлнэ. Үүнд:

- **Хүндэтгэх шалтгаанаар хөдөлмөр эрхлээгүй хүн ам-**Хөдөлмөрийн насны, хөдөлмөрийн чадвартай боловч хүүхэд, өндөр настан, өвчтөн асардаг, 6 сараас дээш хугацаагаар өвчтэй байгаа болон гэр бүлийн хүний ажлын онцлогоос хамааран хөдөлмөр эрхлээгүй хүн ам (энд ажлын байрандаа түр эзгүй байгаа ажиллагчдыг хамруулахгүй)
- **Хөдөлмөр эрхлэх хүсэл сонирхолгүй хүн ам-**хөдөлмөрийн насны, хөдөлмөрлөх чадвартай боловч хөлсний болон хувиараа хөдөлмөрлөж эдийн засгийн үйл ажиллагаанд ажиллах хүчээ нийлүүлэх хүсэл, сонирхолгүй хүн ам.

II. Хүн амын ажил эрхлэлтийн 2008 оны жилийн эцсийн дүнд хийсэн товч танилцуулга

2008 оны эцсийн байдлаар аймгийн нийт хүн амын **64.86** хувь буюу **57.7** мянга нь ажиллах насны хүн ам байгаагийн **64.8** хувь буюу **28.6** мянга нь эмэгтэйчүүд эзлэв. Ажиллах насны хүмүүсийн **74.48** хувь буюу **42.9** мянга нь **ажил эрхэлж, 0.79** хувь буюу **0.46** мянга нь хөдөлмөр зохицуулалтын албанд бүртгэлтэй **ажилгүйчүүд, 4.77** хувь буюу **2.7** мянга нь **хөдөлмөрийн чадваргүй, 12.23** хувь буюу **7.0** мянга нь **ажил эрхлээгүй, 8.1** хувь буюу **4.6** мянга нь **суралцагсад** юм.

Хөдөлмөрийн насны 1000 хүнд ногдох ажиллагчдын тоогоор Баян-Өнжүүл, Алтанбулаг, Дэлгэрхаан, Баянжаргалан, Борнуур сумд (**897-872**) эхний **5-д**, Баян, Баянчандмань, Мөнгөнморьт, Цээл, Зуунмод сумд харьцангуй бага (**585-638**) гарлаа.

Ажиллагсадыг хариуцлагын хэлбэрээр нь авч үзвэл **71.84%** нь Хувиараа хөдөлмөр эрхлэгчид, **0.98%** нь Нөхөрлөлд, **1.59%** нь Хоршоонд, **2.61%** нь ХК-д, **7.50%** нь ХХК-д, **1.75%** нь ТӨҮГазарт, **0.53%** нь ОНӨҮГазарт, **12.23%** нь Төсөвт байгууллагад, **0.94%** нь ТББ-д ажилладгаар бүртгэгджээ.

Ажиллагсадыг өмчийн хэлбэрээр нь авч үзвэл **9.12%** нь МУ-ын төрийн өмчийн, **0.80** нь төрийн өмчийн оролцоотой, **0.64%** нь Гадаадтай хамтарсан үйлдвэрт, **4.94%** нь Орон нутгийн өмчийн, **0.57%** нь Орон нутгийн холимог, **0.20%** нь орон нутгийн гадаадтай хамтарсан, **80.93%** нь МУ-ын иргэний, **2.77%** нь Хувийн гадаадтай хамтарсан газарт ажиллажээ.

Аймгийн хэмжээгээр ажиллаж байгаа хүмүүсийн тоо 2007 оныхоос **2.72** хувь буюу **1.2** мянган хүнээр, үүнээс аж ахуйн газруудад ажиллагсад **2.05** хувь буюу **6.4** мянган хүнээр **буурлаа**.

Аймгийн дүнгээр гарсан **43.4** мянган ажиллах хүчний **98,94** хувь буюу **42.9** мянга нь ажил эрхлэж байгаагийн **47.82** хувь буюу **20.5** мянга нь эмэгтэйчүүд байгаа нь өмнөх оноосоо **0.05** мянгаар буурлаа.

Ажиллах хүчний судалгаагаар гарсан ажилгүйчүүдийн **59.3** хувь нь эмэгтэйчүүд болж 2007 оныхоос **16.26** хувиар **өслөө**.

Хөдөлмөрийн насны 1000 хүнд ногдох ажиллах хүч аймгийн дүнгээр **753** хүн, ажиллагчид **745**, тэжээвэр хүн **542**, үүнээс хүүхэд **434**, өндөр настан **108**, ажилгүйчүүд **8**, ажил эрхлээгүй хүн **123**, хөдөлмөрийн чадваргүй хүн **48** ногдлоо.

Хөдөлмөрийн насны **1000** хүнд ногдох ажиллах хүч, ажиллагсадын тоо өмнөх оноосоо **15-26** хүнээр буурч, тэжээвэр хүмүүсийн тоо дүнгээрээ **4**, үүний дотор хүүхэд **4**, ажил эрхлээгүй хүн **15**-аар тус тус өслөө.

III. СУДАЛГАА

1994-2008 оны хоорондох Ажиллагсадын тооны динамик эгнээний үндсэн үзүүлэлтүүдийг тооцож үзвэл:

1994-2008 оны хоорондох Ажиллагсадын тоог хронологийн дунджын аргаар тооцоход

$$\bar{y} = \frac{y_1 + y_2 + \dots + y_{n-1} + y_n}{n-1} = \frac{585917,0}{14} = 41851,21$$

1994-2008 оны хооронд Ажиллагсадын тоо нь дунджаар 41851 байлаа.

1994-2008 оны ажиллагсадын тооны динамик эгнээний үндсэн үзүүлэлтүүдийн тооцоог дараахь хүснэгтээр харуулав.

Ажиллагсадын тооны динамик эгнээний хэлхээ үндсэн үзүүлэлтүүдийн тооцоолол.

Онууд	Ажиллагсадын тоо	Абсолют цэвэр өсөлт	Хэлхээ өсөлтийн хурд%	Хэлхээ цэвэр өсөлтийн хурд %	Цэвэр өсөлтийн нэг хувьд ногдох утга
1994	34128				
1995	34365	237	100.69	0.69	341
1996	35523	1158	103.37	3.37	344
1997	33727	-1796	94.94	-5.06	355
1998	35389	1662	104.93	4.93	337
1999	35836	447	101.26	1.26	354
2000	37629	1793	105.00	5.00	358
2001	40397	2768	107.36	7.36	376
2002	41780	1383	103.42	3.42	404
2003	42505	725	101.74	1.74	418
2004	41224	-1281	96.99	-3.01	425
2005	42702	1478	103.59	3.59	412
2006	43647	945	102.21	2.21	427
2007	44118	1416	101.08	1.08	436
2008	42947	-700	97.35	-2.65	441

Дээрх хүснэгтээс харахад 2008 онд ажиллагсадын тоо 2007 оныхоос 1.2 хүнээр буюу 2.65 хувиар өсөхөд 1.0 хувьд 441 хүн ногдлоо.

1994 оноос хойших ажиллагсадын тооны өсөлтийн дундаж хурдыг тодорхойлбол:

$$\bar{K} = \sqrt[14]{0.9852 * 1.0069 * \dots * 1.0221 * 1.0108 * 0.9735} = \sqrt[14]{1.1345727} = 1.00922 \text{ буюу гарсан нь}$$

1994 оноос хойш ажиллагсадын тоо жилд дунджаар 0.92% хувиар өссөн гэсэн үг.

Динамик эгнээний үндсэн үзүүлэлтүүдийг хэлхээгээр буюу өмнөх онтой нь харьцуулан гаргахаас гадна тухайн нэг суурь онтой харьцуулан гаргаж болно.

**Ажиллагсадын тооны динамик эгнээний суурь
үндсэн үзүүлэлтүүдийн тооцоолол:**


Онууд	Ажиллаг- садын тоо	Суурь абсолют цэвэр өсөлт (тоо)	Суурь өсөлтийн хурд 1993=100%	Суурь цэвэр өсөлтийн хурд %
1994	34128		100.0	
1995	34365	237	100.69	0.69
1996	35523	1395	104.09	4.09
1997	33727	-401	79.35	-20.65
1998	35389	1261	103.69	3.69
1999	35836	1708	105.00	5.00
2000	37629	3501	110.26	10.26
2001	40397	6269	118.37	18.37
2002	41780	7652	122.42	22.42
2003	42505	8377	124.55	24.55
2004	41224	7096	120.79	20.79
2005	42702	8574	125.12	25.12
2006	43647	9519	127.89	27.89
2007	44118	9990	129.27	29.27
2008	42947	8819	125.84	25.84

Динамик хандлагын шинжилгээ /прогнозчлол/.

Эдийн засгийн аливаа үзэгдэлийг динамикаар судлах үед түүний хөгжлийн ерөнхий зүй тогтол буюу динамик чиг хандлагыг тодорхойлох шаардлага тавигддаг. Аймгийн ажиллагсадын тооны өсөлтийн чиг хандлагыг тодорхойлох, түүнчлэн дараагийн 6 жилийн прогноз боловсруулахын тулд динамик эгнээг тэгшитгэлээр илэрхийлж тооцоо хийх аргыг ашиглаж болох юм. Ингэхдээ 1993-2007 оны хооронд динамик хандлагын шинжилгээг хийлээ. Динамик эгнээг тэгшитгэлээр илэрхийлэх арга гэдэг нь судлагдаж байгаа түвшингүүдийг хугацаанаас хамаарсан функц гэж үзээд динамик эгнээний өгөгдсөн түвшингүүдийг бага хэлбэлзэл бүхий түвшингүүдээр солих арга юм.

Динамик эгнээг тэгшитгэлээр илэрхийлэх аргыг ашиглан 1994-2008 онуудад хүн амын шилжилт зэрэг бусад хүчин зүйлийн нөлөөлөлгүй байсан бол ажиллагсадын тоо ямар түвшинд хүрэх байсан бэ, мөн цаашид дээрхи хүчин зүйлүүд нөлөөлөхгүйгээр байвал ажиллагсадын тоо 2009-2012 онуудад хэдэд хүрэхээр байна нь вэ гэдгийг гаргаж үзлээ. Бидний авч үзэж байгаа динамик эгнээг графикаар дүрсэлж үзэхэд дараахь хэлбэртэй байна.

Ажиллагсадын тооны динамик хандлага



1994 оноос хойшхи 15 жилийн ажиллагсадын тооны бодит утга дээр тулгуурлан шулуун шугамын аргыг ашиглаж тэгшитгэсэн утгыг гаргая. Тэгшитгэл нь $y_{(t)} = a + bt$ томъёогоор илэрхийлнэ. Үүнд: t – хугацаа; a, b – тэгшитгэлийн параметрууд

$$\begin{cases} na + b \sum t = \sum y \\ a \sum t + b \sum t^2 = \sum yt \end{cases}$$

Тэгшитгэлийн параметруудийг дараах систем тэгшитгэлээр бодох бөгөөд

Систем тэгшитгэлийн бодолтыг хялбарчилахын тулд $\sum t = 0$ байхаар хугацаанд t гэсэн код өгвөл системт тэгшитгэл

$$\begin{cases} na = \sum y \\ b \sum t^2 = \sum yt \end{cases} \text{ болно. Системт тэгшитгэлийг бодож гаргахын тулд дараахь тооцооллуудыг}$$

хийе. Y_t – ажиллагсдын тоо, t – хугацаа

Ажиллагсадын тооны динамик эгнээний суурь үндсэн үзүүлэлтийн тооцоолол.

хүснэгт-3

Ажиллагсадын тооны динамик эгнээний
үндсэн үзүүлэлтүүдийн тооцоолол:

Онууд	Y	t	t ²	Y*t	Yt=a+bt
1994	34128	-7	49	-238896	33267.02
1995	34365	-6	36	-206190	34094.75
1996	35523	-5	25	-177615	34922.48
1997	33727	-4	16	-134908	35750.21
1998	35389	-3	9	-106167	36577.94
1999	35836	-2	4	-71672	37405.67
2000	37629	-1	1	-37629	38233.40
2001	40397	0	0	0	39061.13
2002	41780	1	1	41780	39888.86
2003	42505	2	4	85010	40716.59
2004	41224	3	9	123672	41544.32
2005	42702	4	16	170808	42372.05
2006	43647	5	25	218235	43199.78
2007	44118	6	36	264708	44027.51
2008	42947	7	49	300629	44855.24
Дүн	585917		280	231765	
2009		8			45682.97
2010		9			46510.70
2011		10			47338.43
2012		11			48166.16

Эндээс $a=585917/15=39061.13$, $b=231765/280=827.73$ болж, $y_t=39061.13+827.73t$ гэсэн динамик хандлагын тэгшитгэл гарлаа. Уг тэгшитгэлийг ашиглан 1994-2008 онуудад ямар нэгэн сөрөг хүчин зүйлийн нөлөөлөл байхгүй бол ажиллагсадын тоо хэдэд хүрэх, цаашид 2009-2012 онуудад хэдэд хүрэх вэ гэсэн y_t утгыг гарган авлаа.

y - бодит утга буюу гүйцэтгэлээр гарсан ажиллагсадын тоо


y_t - тэгшитгэлээр гарсан ажиллагсадын тоо

Цикл хэлбэлзэлийн шинжилгээ

Динамик хандлагын шинжилгээг хийхдээ хэдийгээр цикл болон гэнэтийн хэлбэлзлийг динамик эгнээнийн бүрэлдэхүүнээс арилгаж математик тэгшитгэлд шилжүүлдэг боловч тухайн үзэгдэлийн цикл хэлбэлзэлийг судлах нь үзэгдлийн өнгөрсөн үеүүдийн хөгжил өөрчлөлтийг илүү тодорхой судалж дүгнэлт гаргахад үр нөлөөтэй байдаг. Цикл хэлбэлзлийн үндсэн үзүүлэлтүүдийг тооцвол

Цикл хэлбэлзлийн үзүүлэлтүүдийн тооцоолол.

	Бодит утга	Тэгшитгэсэн утга	хандлагын хувийн жин	Цикл үлдэгдлийн харьцангуй хэмжигдэхүүн
1994	34128	33267	97.48	-2.52
1995	34365	34095	99.21	-0.79
1996	35523	34922	98.31	-1.69
1997	33727	35750	106.00	6.00
1998	35389	36578	103.36	3.36
1999	35836	37406	104.38	4.38
2000	37629	38233	101.61	1.61
2001	40397	39061	96.69	-3.31
2002	41780	39889	95.47	-4.53
2003	42505	40717	95.79	-4.21
2004	41224	41544	100.78	0.78
2005	42702	42372	99.23	-0.77
2006	43647	43200	98.98	-1.02
2007	44118	44028	99.79	-0.21
2008	42947	44855	104.44	4.44



Ажиллагсадын тоон үзүүлэлтийн 2008 оныг 1997,2001,2007 онуудтай харьцуулсан үзүүлэлт

	1997	2001	2007	2008	Абсолют өсөлт (+), бууралт (-) тоогоор			Жилийн дундаж өсөлт (+) бууралт (-)-ын хувь		
					2008	2008	2008	2008	2008	2008
					1997	2001	2007	1997	2001	2007
1.Алтанбулаг	1500	1563	1735	1691	191	128	-44	1.00	1.13	-2.54
2.Аргалант	828	833	1074	1102	274	269	28	2.41	4.08	2.61
3.Архуст	736	445	444	598	-138	153	154	-1.72	4.31	34.68
4.Батсүмбэр	968	2561	3151	3391	2423	830	240	11.01	4.09	7.62
5.Баян	1350	1022	939	828	-522	-194	-111	-3.99	-2.96	-11.82
6.Баяндэлгэр	606	687	653	662	56	-25	9	0.74	-0.53	1.38
7.Баянжаргалан	667	760	942	838	171	78	-104	1.92	1.41	-11.04
8.Баянөнжүүл	550	1661	1523	1419	869	-242	-104	8.22	-2.22	-6.83
9.Баянхангай	1340	543	708	651	-689	108	-57	-5.84	2.63	-8.05
10.Баянцагаан	1183	1070	1316	1176	-7	106	-140	-0.05	1.36	-10.64
11.Баянцогт	1857	1036	988	965	-892	-71	-23	-5.31	-1.01	-2.33
12.Баянчандмань	1542	1217	1260	1459	-83	242	199	-0.46	2.62	15.79
13.Борнуур	1116	1953	2714	2663	1547	710	-51	7.52	4.53	-1.88
14.Бүрэн	978	1803	1698	1666	688	-137	-32	4.54	-1.12	-1.88
15.Дэлгэрхаан	1190	1148	1081	1047	-143	-101	-34	-1.06	-1.31	-3.15
16.Жаргалант	1238	1969	3024	2996	1758	1027	-28	7.64	6.18	-0.93
17.Заамар	934	2498	2954	2710	1776	212	-244	9.28	1.17	-8.26
18.Лүн	1004	1016	1131	1151	147	135	20	1.15	1.80	1.77
19.Мөнгөнморьт	1094	967	865	770	-324	-197	-95	-2.88	-3.20	-10.98
20.Өндөрширээт	710	1096	1044	1041	331	-55	-3	3.24	-0.73	-0.29
21.Сүмбэр	917	676	880	896	-21	220	16	-0.19	4.11	1.82
22.Сэргэлэн	1090	834	1083	1063	-27	229	-20	-0.21	3.53	-1.85
23.Угтаал	1502	922	1225	1233	-269	311	8	-1.63	4.24	0.65
24.Цээл	2419	1085	1000	971	-1448	-114	-29	-7.32	-1.57	-2.90
25.Эрдэнэ	369	1411	1857	1820	1451	409	-37	14.22	3.70	-1.99
26.Эрдэнэсант	707	2405	2084	2085	1378	-320	1	9.43	-2.02	0.05
27.Зуунмод	5332	6866	6745	6055	723	-811	-690	1.07	-1.78	-10.23
Аймгийн дүн	33727	40047	44118	42947	9220	2900	-1171	2.03	1.00	-2.65

Ажиллагсадын тоо 2009 онд хэдэд хүрч болохыг прогноз хийж үзлээ.

ХҮСНЭГТ-7

Онууд	Бодит утга-Ү	Тэгшитгэсэн утга Yt	Ү-Үt	(Ү-Үt)^2
1994	34.128	33.267	0.86	0.74
1995	34.365	34.095	0.27	0.07
1996	35.523	34.922	0.60	0.36
1997	33.727	35.750	-2.02	4.09
1998	35.389	36.578	-1.19	1.41
1999	35.836	37.406	-1.57	2.46
2000	37.629	38.233	-0.60	0.36
2001	40.397	39.061	1.34	1.78
2002	41.78	39.889	1.89	3.58
2003	42.505	40.717	1.79	3.20
2004	41.224	41.544	-0.32	0.10
2005	42.702	42.372	0.33	0.11
2006	43.647	43.200	0.45	0.20
2007	44.118	44.028	0.09	0.01
2008	42.947	44.855	-1.91	3.64
Дүн				22.13

Үүний тулд доорхи томъёог ашиглана. $y \pm t_{\alpha} * \delta_y$ δ_y - хандлагын (трэндийн) квадрат дундаж

$$\text{хазайлт } \delta_y = \sqrt{\frac{\sum (y - y_t)^2}{n-1}} = \sqrt{\frac{22.13}{15-1}} = 1.257$$

t_{α} - k чөлөөний зэрэг бүхий Стьюдентийн тархалт

$$k=n-1=15-1=14, t(0.05, 14)=2.144788596; \quad t_{\alpha} * \delta_y = 2.144788596 * 1.257 = 2.696$$

$$2009 \text{ оны түвшин } 44.855 + 2.696 = 47.551; \quad 44.551 - 2.696 = 41.855$$

2009 онд ажиллагчдын тоо 41855-ээс 47551 хооронд байх ба энэ нь 95.0 хувийн магадлалтай юм.

IV. ДҮГНЭЛТ, САНАЛ.

Хүн амын ажил эрхлэлтийн тайлангийн гаргалтын чанарыг сайжруулах ажлын хүрээнд : Хүн амын ажил эрхлэлтийн (ХН-1) тайлангийн маягт, заавар, үзүүлэлтийг ҮСХ-ноос боловсруулж гаргасан заавар аргачллын дагуу 27 сумын үндсэн нэгжүүдэд мөрдүүлэн ажиллаж, 2007 онд хамгийн сүүлчийн хувилбараар шинэчилсэн үзүүлэлтүүдээр судалгааг гаргаж хэрэглэгч нарт тархаалаа.

Ажиллагсдын тоо 1993 оноос хойших 15 жилд 2008 оны байдлаар жилд дунджаар 2,2 хувиар өссөн бол 2009 оны эцсийн дүнгээр 1994 оноос жилийн дундаж өсөлт 0.92 хувь буюу 828 хүнээр нэмэгдлээ.

Хүн амын ажил эрхлэлт 1994 оны төвшингээс хамгийн их буурч байсан үе бол 1997 он байлаа. 1994-2000 оны хооронд хүн амын ажил эрхлэлтийн жилийн дундаж аймгийн дүнгээр өсөлт жилд дунджаар -2.03% байлаа.

2008 оны эцэст гарсан хүн амын ажил эрхлэлтийг 1996 онтой харьцуулахад жилд дунджаар 20.8%-иар, 2001 онтой харьцуулахад 6.3%-иар тус бүр нэмэгдлээ. Энэ бүхнээс үзэхэд хүн амын ажил эрхлэлт дээшилж, ажил, хөдөлмөр эрхлэж, аж амьдралаа дээшлүүлэх, зах зээлийн шинэ харилцаанд суралцах хандлага улам бүр нэмэгдэж байгаагийн илрэл юм.

Гэвч аймгийн хэмжээнд ажил эрхлэхгүй байгаа 7067 хүний 22.95 хувь буюу 1622 нь ажил хайж байгаа ба эдгээрийн 1323 нь буюу 81.56 хувь нь **Баян, Баянчандмань, Заамар, Цээл, Эрдэнэсант, Зуунмод (70-545 хүн)** суманд, мөн тодорхой шалтгаангүйгээр ажил эрхлээгүй байгаа 2643 хүн буюу эдгээрийн 2051 нь 77.60 хувь нь **Баянхангай, Заамар, Мөнгөнморьт, Эрдэнэсант, Зуунмод (129- 1384 хүн)** сумдад ногдлоо.

2008 онд ажиллагсдын тоо 1.2 мянган хүнээр буюу 2.72 хувиар буурч цаашид юуны өмнө дээрх сумд ажлын байрыг бий болгож, нэмэгдүүлэх замаар иргэдийнхээ хөдөлмөр эрхлэх боломжийг нэмэгдүүлэхэд өөрсдийн үйл ажиллагаагаа чиглүүлэн ажиллах зорилт тулгамдсан асуудал боллоо.

2009 онд **Өрхийн үйлдвэрлэлийг дэмжих жил** болгосонтой уялдуулан өрхийн амьжиргааг дэмжих төсөл, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан зэрэг харьцангуй бага зээлийн хүүтэй эх үүсвэрүүдийг дайчлан сумдад байнгын орлогын эх үүсвэр бүхий ажлын байрыг бий болгоход зориулан олгож зах зээлийн жишигт зохицсон хөдөлмөр эрхлэлтийн менежментийн арга барилыг хамгийн оновчтой хэлбэрээр үр өгөөжтэй хэрэгжүүлэхэд сум бүр үйл ажиллагаагаа чиглүүлэх шаардлагатай .

2009-2012 онуудад **ажил эрхлэх насны хүн амын тоо жил бүр 828** орчим хүнээр нас дэвшиж нэмэгдэх чиг хандлага байгаад анхаарлаа хандуулж хөдөлмөрийн зах зээлийн харилцааг зохицуулах бодлого чиглэлд тусгаж хэрэгжүүлэх хэрэгтэйг зөвлөө.

Статистикийн хэлтсийн

дарга

Ж.Отгончулуун.

ХАВСРАЛТЫН ЖАГСААЛТ

1. Суурин болон хөдөлмөрийн насны хүн амын тоо.
2. Суурин хүн амын тоо, насны бүлгээр.
3. Суурин эмэгтэй хүн амын тоо, насны бүлгээр.
4. Хөдөлмөрийн насны хүн ам, насны бүлгээр.
5. Хөдөлмөрийн насны хүн ам, насны бүлэг, хувийн жин
6. Хөдөлмөрийн насны эмэгтэй хүн ам, насны бүлгээр.
7. Хөдөлмөрийн насны эмэгтэй хүн ам, насны бүлэг, хувийн жин
8. Ажиллах хүчний бүтэц. (тоо, хувиар)
9. Ажиллах хүч бүгд сумдаар
10. Ажиллагчид бүгд сумдаар
11. Ажиллагчид бүгд насны бүлэг, сумдаар
12. Ажиллагчдаас эмэгтэйчүүд насны бүлэг, сумдаар
13. Хөдөлмөр зохицуулалтын албанд бүртгэлтэй ажилгүйчүүд сумдаар
14. Хөдөлмөр зохицуулалтын албанд бүртгэлтэй эмэгтэй ажилгүйчүүд сумдаар
15. ХЗАБ-тэй ажилгүйчүүдээс анх удаа, урьд нь ажиллаж байсан, сумдаар
16. Ажилгүйчүүд эдийн засгийн идвэхтэй хүн амд эзлэх хувийн жин
17. Хөдөлмөрийн насны хүн амаас ажиллаж байгаа нь сумдаар
18. Хөдөлмөрийн насны хүн амаас ажиллаж байгаа эмэгтэйчүүд сумдаар
19. Хөдөлмөрийн насны 1000 хүнд ногдох ажиллах хүч, ажиллагсад.
20. Хөдөлмөрийн насны 1000 хүнд ногдох тэжээвэр хүмүүс.
21. Хөдөлмөрийн насны хүн амаас хөдөлмөр эрхлээгүй, хөдөлмөрийн чадваргүй, хөдөлмөрийн насны суралцагсад.
22. Хөдөлмөрийн насны 1000 хүнд ногдох ажилгүйчүүд, ажил эрхлээгүй, хөдөлмөрийн чадваргүй хүмүүс.
23. Ажиллагсад эдийн засгийн үйл ажиллагааны салбрын дүнгээр. (аж ахуйн газрууд)
24. Ажиллагсад эдийн засгийн үйл ажиллагааны салбрын дүн. (төсвийн болон бусад)
25. Ажиллагсад сумдаар (аж ахуйн газрууд)
26. Ажиллагсад аж ахуйн газрууд сумдаар (эмэгтэйчүүд)
27. Ажиллагсад сумдаар (төсвийн болон бусад)
28. Ажиллагсад сумдаар (эмэгтэйчүүд)
29. Ажиллагсад өмчийн хэлбэрээр (бүгд.)
30. Ажиллагсад өмчийн хэлбэрээр (эмэгтэйчүүд)
31. Ажил эрхлээгүй хөдөлмөрийн насны хүн ам насны бүлэг, шалтгаан, дүнгээр
32. Ажил эрхлээгүй хөдөлмөрийн насны хүн ам насны бүлэг, шалтгаан, дүнгээр (эмэгтэйчүүд)
33. Ажил эрхлээгүй хөдөлмөрийн насны хүн ам насны бүлэг. (сумдаар)
34. Ажил эрхлээгүй хөдөлмөрийн насны хүн шалтгаанаар.
35. Ажил эрхлээгүй хөдөлмөрийн насны тодорхой шалтгаангүй хүмүүс нас, хүйсээр.
36. Ажиллагсадын тоо ажил мэргэжил, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын чиглэлээр (аж ахуйн газруудын дүнгээр)
37. Ажиллагсадын тоо ажил мэргэжил, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын чиглэлээр (нийгмийн хүрээний салбаруудын дүн.)

38. Ажиллагсадын тоо ажил мэргэжил,эдийн засгийн үйл ажиллагааны салбарын чиглэлээр (ахуйн газруудын дүнгээр эмэгтэй)
39. Ажиллагсадын тоо, өмчийн хэлбэр, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангилалаар (.бүгд дүн)
40. Ажиллагсадын тоо, өмчийн хэлбэр, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангилалаар (хувийн жингээр)
41. Ажиллагсадын тоо, өмчийн хэлбэр, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангилалаар (эмэгтэй.)
42. Ажиллагсадын тоо,боловсролын түвшин,эдийн засгийн үйл ажиллагааны салбарын дүнгээр
43. Ажиллагсадын тоо,боловсролын түвшин,эдийн засгийн үйл ажиллагааны салбарын дүн хувиар
44. Ажиллагсадын тоо,боловсролын түвшин,эдийн засгийн үйл ажиллагааны салбарын дүн эмэгтэйчүүд
45. Ажиллагсадын тоо,боловсролын түвшин,эдийн засгийн үйл ажиллагааны салбарын дүн эмэгтэйн хувь
46. Ажиллагсадын тоо,боловсролоор сумдаар.
47. Ажиллагсадын тоо,боловсролоор сумдаар (эмэгтэй)
48. Хүн амын тоо,хөдөлмөрийн насны хүн амын ангилал сумдын дүнгээр.
49. Хүн амын тоо,хөдөлмөрийн насны хүн амын ангилал сумдаар .(эмэгтэй)
50. Ажиллагсад ажил эрхлэлтийн танилцуулгатай холбоотой графикууд.

**Хүн амын ажил эрхлэлтийн судалгаагаар
хамгийн их, бага үзүүлэлттэй сумд**

	Хэмжих нэгж	2008 оны				
		Аймгийн дундаж	Хамгийн			
			их	бага		
Хөдөлмөрийн насны хүн амын тоогоор	хүн	57660	Зуунмод	10222	Баяндэлгэр	783
			Батсүмбэр	3927	Архуст	856
			Жаргалант	3845	Баянхангай	949
			Заамар	3826	Сүмбэр	1128
			Эрдэнэсант	2972	Дэлгэрхаан	1171
Ажиллах хүчний тоогоор	хүн	43407	Зуунмод	6170	Архуст	615
			Батсүмбэр	3408	Баяндэлгэр	665
			Жаргалант	3022	Баянхангай	669
			Заамар	2717	Мөнгөнморьт	772
			Борнуур	2693	Баян	829
Ажиллагчдын тоогоор	хүн	42947	Зуунмод	6055	Архуст	598
			Батсүмбэр	3391	Баяндэлгэр	662
			Жаргалант	2996	Баянхангай	651
			Заамар	2710	Мөнгөнморьт	770
			Борнуур	2663	Баян	828
Ажиллаж байгаа хөдөлмөрийн насны хүнээр	хүн	43922	Зуунмод	6740	Архуст	444
			Батсүмбэр	3151	Баяндэлгэр	653
			Жаргалант	3024	Баянхангай	708
			Заамар	2954	Мөнгөнморьт	865
			Борнуур	2714	Сүмбэр	880
Ажилгүйчүүдийн тоогоор	хүн	460	Зуунмод	115	Баянцагаан	0
			Цээл	37	Аргалант	1
			Борнуур	30	Баян	1
			Баянчандмань	28	Эрдэнэсант	2
			Сэргэлэн	28	Баяндэлгэр	3
Хөдөлмөрийн насны хүнээс хөдөлмөр эрхлээгүй	хүн	7067	Зуунмод	2560	Өндөрширээт	35
			Эрдэнэсант	554	Баяндэлгэр	39
			Заамар	524	Баяннөжүүл	41
			Цээл	360	Бүрэн	41
			Баянчандмань	349	Дэлгэрхаан	46
Эдийн засгийн идэвхитэй хүн амд ажилгүйчүүдийн эзлэх хувь	хувь	1.07	Цээл	3.8	Аргалант	0.1
			Архуст	2.8	Эрдэнэсант	0.1
			Баянхангай	2.8	Баян	0.1
			Сэргэлэн	2.6	Заамар	0.3
			Зуунмод	1.9	Дэлгэрхаан	0.3
Хөдөлмөрийн насны 1000 хүнд ногдох ажиллах хүч	хүн	753	Бүрэн	908	Баянчандмань	597
			Борнуур	907	Зуунмод	604
			Дэлгэрхаан	897	Мөнгөнморьт	612
			Баяннөжүүл	895	Цээл	635
			Алтанбулаг	883	Баян	639
Хөдөлмөрийн насны 1000 хүнд ногдох ажиллагчдын тоо	хүн	745	Борнуур	897	Баянчандмань	585
			Бүрэн	896	Зуунмод	592
			Дэлгэрхаан	894	Мөнгөнморьт	611
			Баяннөжүүл	891	Цээл	612
			Алтанбулаг	872	Баян	638

үргэлжлэл

	Хэмжих нэгж	2008 оны				
		Аймгийн дундаж	Хамгийн			
			их	бага		
Хөдөлмөрийн насны 1000 хүнд ногдох тэжээвэр хүний тоо бүгд	хүн	542	Бүрэн	644	Сэргэлэн	452
			Дэлгэрхаан	640	Баяннөжүүл	459
			Батсүмбэр	635	Аргалант	480
			Баян	596	Баяндэлгэр	493
			Эрдэнэ	581	Зуунмод	493
Хөдөлмөрийн насны 1000 хүнд ногдох тэжээвэр хүнээс хүүхдийн тоо	хүн	434	Дэлгэрхаан	535	Аргалант	334
			Бүрэн	522	Сэргэлэн	352
			Баянжаргалан	486	Баянцагаан	369
			Заамар	483	Баяннөжүүл	377
			Батсүмбэр	475	Баяндэлгэр	378
Хөдөлмөрийн насны 1000 хүнд ногдох тэжээвэр хүнээс өндөр настан	хүн	108	Батсүмбэр	160	Заамар	56
			Аргалант	146	Сүмбэр	78
			Бүрэн	122	Цээл	81
			Эрдэнэ	121	Баянхангай	82
			Баянчандмань	118	Баяннөжүүл	82
Хөдөлмөрийн насны 1000 хүнд ногдох ажилгүйчүүд	хүн	8	Цээл	23	Баянцагаан	-
			Сэргэлэн	21.5	Мөнгөнморьт	1.6
			Архуст	19.9	Эрдэнэсант	7
			Баянхангай	19	Аргалант	8
			Бүрэн	12	Баян	8
Хөдөлмөрийн насны 1000 хүнд ногдох ажил эрхлээгүй хүн	хүн	123	Баянхангай	251	Батсүмбэр	18
			Зуунмод	250	Борнуур	19
			Цээл	227	Баян-Өнжүүл	26
			Баян	214	Өндөрширээт	27
			Эрдэнэсант	186	Дэлгэрхаан	39
Хөдөлмөрийн насны 1000 хүнд ногдох хөдөлмөрийн чадваргүй хүн	хүн	48	Сүмбэр	86	Баянхангай	16
			Дэлгэрхаан	79	Заамар	20
			Угтаал	77	Сэргэлэн	21
			Лүн	77	Аргалант	27
			Архуст	76	Борнуур	33

Суурин болон хөдөлмөрийн насны хүн амын тоо

	Суурин хүн ам			Хөдөлмөрийн насны хүн ам			суурин хүн амд хөдөлмөрийн насныхны эзлэх %		Аймгийн дүнд эзлэх хувийн жин
	Бүгд	үүнээс эмэгтэй	хувь	Бүгд	үүнээс эмэгтэй	хувь	бүгд	эмэгтэй	
1.Алтанбулаг	3044	1472	48.4	1939	941	48.5	63.7	63.9	3.42
2.Аргалант	1964	987	50.3	1327	667	50.3	67.6	67.6	2.21
3.Архуст	1339	657	49.1	856	419	48.9	63.9	63.8	1.51
4.Батсүмбэр	6420	3152	49.1	3927	1936	49.3	61.2	61.4	7.22
5.Баян	2072	1075	51.9	1298	664	51.2	62.6	61.8	2.33
6.Баяндэлгэр	1169	524	44.8	783	345	44.1	67.0	65.8	1.32
7.Баянжаргалан	1604	809	50.4	1034	510	49.3	64.5	63.0	1.80
8.Баянөнжүүл	2324	1115	48.0	1593	765	48.0	68.5	68.6	2.61
9.Баянхангай	1443	729	50.5	949	485	51.1	65.8	66.5	1.62
10.Баянцагаан	2094	1023	48.9	1413	674	47.7	67.5	65.9	2.36
11.Баянцогт	2032	961	47.3	1322	645	48.8	65.1	67.1	2.29
12.Баянчандмань	3797	1752	46.1	2493	1126	45.2	65.7	64.3	4.27
13.Борнуур	4677	2327	49.8	2970	1451	48.9	63.5	62.4	5.26
14.Бүрэн	3056	1528	50.0	1859	900	48.4	60.8	58.9	3.44
15.Дэлгэрхаан	1920	946	49.3	1171	574	49.0	61.0	60.7	2.16
16.Жаргалант	5981	2938	49.1	3845	1887	49.1	64.3	64.2	6.73
17.Заамар	5887	2910	49.4	3826	1927	50.4	65.0	66.2	6.62
18.Лүн	2485	1213	48.8	1620	804	49.6	65.2	66.3	2.80
19.Мөнгөнморьт	1938	928	47.9	1261	577	45.8	65.1	62.2	2.18
20.Өндөрширээт	1982	944	47.6	1277	616	48.2	64.4	65.3	2.23
21.Сүмбэр	1709	889	52.0	1128	576	51.1	66.0	64.8	1.92
22.Сэргэлэн	1893	913	48.2	1304	633	48.5	68.9	69.3	2.13
23.Угтаал	2276	1154	50.7	1451	732	50.4	63.8	63.4	2.56
24.Цээл	2402	1189	49.5	1587	784	49.4	66.1	65.9	2.70
25.Эрдэнэ	3531	1744	49.4	2233	1106	49.5	63.2	63.4	3.97
26.Эрдэнэсант	4586	2289	49.9	2972	1475	49.6	64.8	64.4	5.16
27.Зуунмод	15264	7955	52.1	10222	5405	52.9	67.0	67.9	17.17
Аймгийн дүн	88889	44123	49.6	57660	28624	49.6	64.9	64.9	100
Дүнгээс: Төв	24619	12478	50.7	16471	8418	51.1	66.9	67.5	27.70
бүс- Хойт	26580	13006	48.9	17012	8288	48.7	64.0	63.7	29.90
үүдээр Баруун	26037	12902	49.6	16712	8297	49.6	64.2	64.3	29.29
Зүүн	11653	5737	49.2	7465	3621	48.5	64.1	63.1	13.11
2007 он	88828	44368	49.9	57454	28775	50.1	64.7	64.9	
2006 он	88460	44499	50.3	56347	28454	50.5	63.7	63.9	
2005 он	88491	44505	50.3	55280	27912	50.5	62.5	62.7	
2004 он	88627	44417	50.1	54552	27370	50.2	61.6	61.6	
2003 он	92816	46603	50.2	55836	28222	50.5	60.2	60.6	
2002 он	96176	47938	49.8	56427	28301	50.2	58.7	59.0	
2001 он	95706	47605	49.7	55128	27588	50.0	57.6	58.0	
2000 он	98362	48223	49.0	53141	25264	47.5	54.0	52.4	
1999 он	101112	50483	49.9	55135	26866	48.7	54.5	53.2	
1998 он	103537	51770	50.0	55459	27002	48.7	53.6	52.2	

Суурин хүн ам, насны бүлгээр.

	Суурин хүн ам	Ү Ү Н Э Э С											Аймгийн дүнд эзлэх хувийн жин
		16 хүр тэл	16-19	20-24	25-29	30-34	35-39	40-44	45-49	50-54	55-59	60 +	
1.Алтанбулаг	3044	877	332	339	245	210	217	171	204	128	93	228	3.42
2.Аргалант	1964	443	216	251	193	147	108	126	127	84	75	194	2.21
3.Архуст	1339	390	140	149	98	95	94	99	89	62	30	93	1.51
4.Батсүмбэр	6420	1866	597	596	496	482	451	430	350	308	217	627	7.22
5.Баян	2072	631	191	207	177	181	156	127	124	80	55	143	2.33
6.Баяндэлгэр	1169	296	82	102	92	90	110	79	104	89	35	90	1.32
7.Баянжаргалан	1604	482	174	179	149	120	122	85	83	79	43	88	1.80
8.Баянөнжүүл	2324	600	216	227	257	225	182	172	155	98	61	131	2.61
9.Баянхангай	1443	416	134	161	160	127	86	73	84	80	44	78	1.62
10.Баянцагаан	2094	522	174	232	218	214	153	130	120	104	68	159	2.36
11.Баянцогт	2032	562	218	217	167	144	139	142	99	105	91	148	2.29
12.Баянчандмань	3797	1009	617	365	253	258	232	246	234	173	115	295	4.27
13.Борнуур	4677	1401	469	523	406	370	298	298	282	201	123	306	5.26
14.Бүрэн	3056	971	301	320	271	255	208	161	147	122	74	226	3.44
15.Дэлгэрхаан	1920	626	197	211	200	152	118	103	90	55	45	123	2.16
16.Жаргалант	5981	1762	592	639	540	463	459	413	284	280	175	374	6.73
17.Заамар	5887	1847	534	643	543	557	463	395	361	207	123	214	6.62
18.Лүн	2485	691	244	291	191	200	180	160	134	133	87	174	2.80
19.Мөнгөнморьт	1938	551	192	193	155	151	143	131	131	115	50	126	2.18
20.Өндөрширээт	1982	574	186	234	195	148	135	105	116	97	61	131	2.23
21.Сүмбэр	1709	493	164	205	170	142	136	115	97	48	51	88	1.92
22.Сэргэлэн	1893	459	152	202	214	201	155	117	97	108	58	130	2.13
23.Угтаал	2276	659	259	246	175	168	138	171	138	84	72	166	2.56
24.Цээл	2402	686	269	281	218	167	157	152	144	128	71	129	2.70
25.Эрдэнэ	3531	1028	359	404	283	275	215	211	197	158	131	270	3.97
26.Эрдэнэсант	4586	1300	487	563	349	319	334	311	291	186	132	314	5.16
27.Зуунмод	15264	3881	1582	1730	1406	1194	1104	1027	1007	704	468	1161	17.17
Аймгийн дүн	88889	25023	9078	9710	7821	7055	6293	5750	5289	4016	2648	6206	100
Дүнгээс: Төв	24619	6339	2456	2730	2340	2044	1811	1617	1583	1142	748	1809	27.70
бүс- Хойт	26580	7536	2873	2796	2225	2006	1823	1770	1473	1199	847	2032	29.90
үүдээр Баруун	26037	7770	2611	2950	2302	2093	1819	1631	1505	1092	709	1555	29.29
Зүүн	11653	3378	1138	1234	954	912	840	732	728	583	344	810	13.11
2007 он	88828	25163	9383	9544	7859	7022	6261	5814	5211	3802	2558	6211	
2006 он	88460	25963	9452	9262	7888	7110	6077	5589	4946	3671	2352	6150	
2005 он	88491	27020	9519	9125	7659	6821	6016	5548	4792	3465	2335	6191	
2004 он	88627	28089	9370	8950	7726	6783	6062	5688	4614	3203	2156	5986	
2003 он	92816	30681	9508	9521	8188	6964	6266	5649	4410	3131	2199	6299	
2002 он	96176	33141	9545	9812	8305	7107	6377	5691	4268	3023	2299	6608	
2001 он	95706	33984	8930	9583	8714	6790	6248	5573	4006	2823	2461	6594	
2000 он	98362	37634	8802	9175	8301	7201	6569	5486	3702	2712	2348	6432	
1999 он	101112	38170	9375	10742	8204	6988	6518	5307	3762	2664	3127	6255	
1998 он	103537	39942	9536	10409	8367	7312	6668	5172	3697	2741	3134	6559	

Суурин эмэгтэй хүн ам, насны бүлгээр.

	Суурин хүн ам	Ү Ү Н Э Э С											Аймгийн дүнд эз- лэх хув- ийн жин
		16 хүр тэл	16-19	20-24	25-29	30-34	35-39	40-44	45-49	50-54	55-59	60 +	
1.Алтанбулаг	1472	411	149	163	116	100	118	80	106	65	44	120	3.34
2.Аргалант	987	218	105	123	93	68	61	65	66	42	44	102	2.24
3.Архуст	657	188	69	63	48	47	53	49	41	37	12	50	1.49
4.Батсүмбэр	3152	913	285	299	237	238	226	216	158	161	116	303	7.14
5.Баян	1075	336	99	109	91	93	77	68	60	46	21	75	2.44
6.Баяндэлгэр	524	141	43	46	35	28	46	34	54	39	20	38	1.19
7.Баянжаргалан	809	253	97	88	67	60	55	42	41	44	16	46	1.83
8.Баяннөжүүл	1115	275	105	110	112	104	89	87	78	50	30	75	2.53
9.Баянхангай	729	199	61	89	85	69	37	43	41	40	20	45	1.65
10.Баянцагаан	1023	258	88	102	102	100	78	64	47	59	34	91	2.32
11.Баянцогт	961	246	114	116	75	65	62	73	47	54	39	70	2.18
12.Баянчандмань	1752	474	227	168	134	109	110	118	119	90	51	152	3.97
13.Борнуур	2327	702	232	231	191	170	150	165	142	101	69	174	5.27
14.Бүрэн	1528	504	142	135	137	115	107	86	74	62	42	124	3.46
15.Дэлгэрхаан	946	312	91	109	97	63	59	58	41	33	23	60	2.14
16.Жаргалант	2938	864	311	288	267	225	221	198	159	130	88	187	6.66
17.Заамар	2910	876	265	318	277	283	234	201	172	116	61	107	6.60
18.Лүн	1213	325	114	151	84	98	87	92	68	65	45	84	2.75
19.Мөнгөнморьт	928	277	86	92	72	63	72	64	55	53	20	74	2.10
20.Өндөрширээт	944	268	80	112	98	69	63	51	63	47	33	60	2.14
21.Сүмбэр	889	262	90	105	85	76	74	53	42	20	31	51	2.01
22.Сэргэлэн	913	211	74	96	104	102	68	54	51	61	23	69	2.07
23.Угтаал	1154	333	125	130	85	85	68	87	74	38	40	89	2.62
24.Цээл	1189	332	150	140	91	82	72	72	82	69	26	73	2.69
25.Эрдэнэ	1744	496	181	202	146	127	100	104	94	86	66	142	3.95
26.Эрдэнэсант	2289	650	259	269	158	162	175	152	135	97	68	164	5.19
27.Зуунмод	7955	1906	819	878	745	627	627	553	537	383	236	644	18.03
Аймгийн дүн	44123	12230	4461	4732	3832	3428	3189	2929	2647	2088	1318	3269	100
Дүнгээс: Төв	12478	3061	1235	1349	1179	1033	980	838	819	618	367	999	28.28
бүс- Хойт	13006	3679	1364	1330	1082	951	904	888	733	598	438	1039	29.48
үүдээр Баруун	12902	3799	1287	1453	1112	1026	902	842	750	567	358	806	29.24
Зүүн	5737	1691	575	600	459	418	403	361	345	305	155	425	13.00
2007 он	44368	12295	4704	4694	3930	3496	3154	2977	2590	1910	1320	3298	
2006 он	44498	12768	4763	4652	3942	3583	3074	2873	2553	1828	1186	3276	
2005 он	44505	13321	4771	4597	3827	3399	3074	2862	2446	1727	1209	3272	
2004 он	44417	13916	4577	4494	3846	3402	3100	2903	2362	1589	1097	3131	
2003 он	46603	15100	4730	4873	4105	3540	3205	2831	2274	1574	1090	3281	
2002 он	47938	16229	4735	4905	4166	3543	3205	2885	2174	1553	1135	3408	
2001 он	47605	16650	4376	4758	4333	3447	3169	2827	2004	1446	1228	3367	
2000 он	48223	18529	4129	4348	4110	3604	3256	2674	1764	1379	1155	3275	
1999 он	50483	18815	4654	5385	4086	3625	3241	2658	1894	1323	1552	3250	
1998 он	51772	19805	4759	5165	4178	3695	3381	2589	1880	1355	1577	3388	

**Хөдөлмөрийн насны хүн амыг
насны бүлгээр нь үзүүлбэл:**

(Бүгд дүн)

	Хөдөл- мөрийн насны хүн бүгд	Ү Ү н э э с									Аймгийн дүнд эз- лэх хув- ийн жин
		16-19 насны	20-24	25-29	30-34	35-39	40-44	45-49	50-54	55-59	
1.Алтанбулаг	1939	332	339	245	210	217	171	204	128	93	3.36
2.Аргалант	1327	216	251	193	147	108	126	127	84	75	2.30
3.Архуст	856	140	149	98	95	94	99	89	62	30	1.48
4.Батсүмбэр	3927	597	596	496	482	451	430	350	308	217	6.81
5.Баян	1298	191	207	177	181	156	127	124	80	55	2.25
6.Баяндэлгэр	783	82	102	92	90	110	79	104	89	35	1.36
7.Баянжаргалан	1034	174	179	149	120	122	85	83	79	43	1.79
8.Баянөнжүүл	1593	216	227	257	225	182	172	155	98	61	2.76
9.Баянхангай	949	134	161	160	127	86	73	84	80	44	1.65
10.Баянцагаан	1413	174	232	218	214	153	130	120	104	68	2.45
11.Баянцогт	1322	218	217	167	144	139	142	99	105	91	2.29
12.Баянчандмань	2493	617	365	253	258	232	246	234	173	115	4.32
13.Борнуур	2970	469	523	406	370	298	298	282	201	123	5.15
14.Бүрэн	1859	301	320	271	255	208	161	147	122	74	3.22
15.Дэлгэрхаан	1171	197	211	200	152	118	103	90	55	45	2.03
16.Жаргалант	3845	592	639	540	463	459	413	284	280	175	6.67
17.Заамар	3826	534	643	543	557	463	395	361	207	123	6.64
18.Лүн	1620	244	291	191	200	180	160	134	133	87	2.81
19.Мөнгөнморьт	1261	192	193	155	151	143	131	131	115	50	2.19
20.Өндөрширээт	1277	186	234	195	148	135	105	116	97	61	2.21
21.Сүмбэр	1128	164	205	170	142	136	115	97	48	51	1.96
22.Сэргэлэн	1304	152	202	214	201	155	117	97	108	58	2.26
23.Угтаал	1451	259	246	175	168	138	171	138	84	72	2.52
24.Цээл	1587	269	281	218	167	157	152	144	128	71	2.75
25.Эрдэнэ	2233	359	404	283	275	215	211	197	158	131	3.87
26.Эрдэнэсант	2972	487	563	349	319	334	311	291	186	132	5.15
27.Зуунмод	10222	1582	1730	1406	1194	1104	1027	1007	704	468	17.73
Аймгийн дүн	57660	9078	9710	7821	7055	6293	5750	5289	4016	2648	100
Дүнгээс: Төв	16471	2456	2730	2340	2044	1811	1617	1583	1142	748	28.57
бүс- Хойт	17012	2873	2796	2225	2006	1823	1770	1473	1199	847	29.50
үүдээр Баруун	16712	2611	2950	2302	2093	1819	1631	1505	1092	709	28.98
Зүүн	7465	1138	1234	954	912	840	732	728	583	344	12.95
2007 он	57454	9383	9544	7859	7022	6261	5814	5211	3802	2558	
2006 он	56347	9452	9262	7888	7110	6077	5589	4946	3671	2352	
2005 он	55280	9519	9125	7659	6821	6016	5548	4792	3465	2335	
2004 он	54552	9370	8950	7726	6783	6062	5688	4614	3203	2156	
2003 он	55836	9508	9521	8188	6964	6266	5649	4410	3131	2199	
2002 он	56427	9545	9812	8305	7107	6377	5691	4268	3023	2299	
2001 он	55128	8930	9583	8714	6790	6248	5573	4006	2823	2461	
2000 он	53141	8802	9175	8301	7201	6569	5486	3702	2712	1193	
1999 он	55135	9578	10539	8204	6988	6538	5307	3752	2654	1575	
1998 он	55459	9536	10409	8367	7312	6668	5172	3697	2741	1557	

**Хөдөлмөрийн насны хүн амыг
насны бүлгээр нь үзүүлбэл:**

(хувиар)

	Хөдөл- мөрийн насны хүн бүгд	Ү Ү Н Э Э С								
		16-19 насны	20-24	25-29	30-34	35-39	40-44	45-49	50-54	55-59
1.Алтанбулаг	100	15.83	17.32	12.33	10.63	12.54	8.50	11.26	6.91	4.68
2.Аргалант	100	15.74	18.44	13.94	10.19	9.15	9.75	9.90	6.30	6.60
3.Архуст	100	16.47	15.04	11.46	11.22	12.65	11.69	9.79	8.83	2.86
4.Батсүмбэр	100	14.72	15.44	12.24	12.29	11.67	11.16	8.16	8.32	5.99
5.Баян	100	14.91	16.42	13.70	14.01	11.60	10.24	9.04	6.93	3.16
6.Баяндэлгэр	100	12.46	13.33	10.14	8.12	13.33	9.86	15.65	11.30	5.80
7.Баянжаргалан	100	19.02	17.25	13.14	11.76	10.78	8.24	8.04	8.63	3.14
8.Баянөнжүүл	100	13.73	14.38	14.64	13.59	11.63	11.37	10.20	6.54	3.92
9.Баянхангай	100	12.58	18.35	17.53	14.23	7.63	8.87	8.45	8.25	4.12
10.Баянцагаан	100	13.06	15.13	15.13	14.84	11.57	9.50	6.97	8.75	5.04
11.Баянцогт	100	17.67	17.98	11.63	10.08	9.61	11.32	7.29	8.37	6.05
12.Баянчандмань	100	20.16	14.92	11.90	9.68	9.77	10.48	10.57	7.99	4.53
13.Борнуур	100	15.99	15.92	13.16	11.72	10.34	11.37	9.79	6.96	4.76
14.Бүрэн	100	15.78	15.00	15.22	12.78	11.89	9.56	8.22	6.89	4.67
15.Дэлгэрхаан	100	15.85	18.99	16.90	10.98	10.28	10.10	7.14	5.75	4.01
16.Жаргалант	100	16.48	15.26	14.15	11.92	11.71	10.49	8.43	6.89	4.66
17.Заамар	100	13.75	16.50	14.37	14.69	12.14	10.43	8.93	6.02	3.17
18.Лүн	100	14.18	18.78	10.45	12.19	10.82	11.44	8.46	8.08	5.60
19.Мөнгөнморьт	100	14.90	15.94	12.48	10.92	12.48	11.09	9.53	9.19	3.47
20.Өндөрширээт	100	12.99	18.18	15.91	11.20	10.23	8.28	10.23	7.63	5.36
21.Сүмбэр	100	15.63	18.23	14.76	13.19	12.85	9.20	7.29	3.47	5.38
22.Сэргэлэн	100	11.69	15.17	16.43	16.11	10.74	8.53	8.06	9.64	3.63
23.Угтаал	100	17.08	17.76	11.61	11.61	9.29	11.89	10.11	5.19	5.46
24.Цээл	100	19.13	17.86	11.61	10.46	9.18	9.18	10.46	8.80	3.32
25.Эрдэнэ	100	16.37	18.26	13.20	11.48	9.04	9.40	8.50	7.78	5.97
26.Эрдэнэсант	100	17.56	18.24	10.71	10.98	11.86	10.31	9.15	6.58	4.61
27.Зуунмод	100	15.15	16.24	13.78	11.60	11.60	10.23	9.94	7.09	4.37
Аймгийн дүн	100	15.58	16.53	13.39	11.98	11.14	10.23	9.25	7.29	4.60
Дүнгээс: Төв	100	14.37	16.05	13.85	13.23	11.67	9.64	9.13	7.68	4.38
бүс- Хойт	100	15.34	17.14	14.16	11.64	10.15	10.12	8.68	7.80	4.98
үүдээр Баруун	100	16.46	16.93	13.61	12.00	10.72	9.89	8.69	7.36	4.34
Зүүн	100	15.46	16.41	12.62	12.41	11.65	10.65	9.55	7.03	4.22
2007 он	100	16.33	16.61	13.68	12.22	10.90	10.12	9.07	6.62	4.45
2006 он	100	16.77	16.44	14.00	12.62	10.78	9.92	8.78	6.51	4.17
2005 он	100	17.22	16.51	13.85	12.34	10.88	10.04	8.67	6.27	4.22
2004 он	100	17.18	16.41	14.16	12.43	11.11	10.43	8.46	5.87	3.95
2003 он	100	17.03	17.05	14.66	12.47	11.22	10.12	7.90	5.61	3.94
2002 он	100	16.92	17.39	14.72	12.60	11.30	10.09	7.56	5.36	4.07
2001 он	100	16.20	17.38	15.81	12.32	11.33	10.11	7.27	5.12	4.46
2000 он	100	16.50	17.30	15.60	13.60	12.40	10.30	7.00	5.10	2.20
1999 он	100	17.40	19.10	14.90	12.70	11.90	9.60	6.80	4.80	2.80
1998 он	100	17.19	18.77	15.09	13.18	12.02	9.33	6.67	4.94	2.81

**Хөдөлмөрийн насны Эмэгтэйчүүдийг
насны бүлгээр нь үзүүлбэл:**

	Хөдөл- мөрийн насны хүн бүгд	Ү Ү н э э с									Аймгийн дүнд эз- лэх хув- ийн жин
		16-19 насны	20-24	25-29	30-34	35-39	40-44	45-49	50-54	55-59	
1.Алтанбулаг	941	149	163	116	100	118	80	106	65	44	3.29
2.Аргалант	667	105	123	93	68	61	65	66	42	44	2.33
3.Архуст	419	69	63	48	47	53	49	41	37	12	1.46
4.Батсүмбэр	1936	285	299	237	238	226	216	158	161	116	6.76
5.Баян	664	99	109	91	93	77	68	60	46	21	2.32
6.Баяндэлгэр	345	43	46	35	28	46	34	54	39	20	1.21
7.Баянжаргалан	510	97	88	67	60	55	42	41	44	16	1.78
8.Баянөнжүүл	765	105	110	112	104	89	87	78	50	30	2.67
9.Баянхангай	485	61	89	85	69	37	43	41	40	20	1.69
